

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/198/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodoli@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
Аудитаар албан шаардлага өгөх асуудал илрээгүй.	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэлийн

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 91
танай _____ ны № _____ т

АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.АЛДАРМӨНХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Соёл урлагийн газар 1 хөтөлбөр 2 зориулалт арга хэмжээний хүрээнд 215,954.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 143,097.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний А/398 тоот захирамжаар 3 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэснийг Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 тоот тушаалаар бүтэц орон тоог 11-ээр баталжээ.

D:/bichighereg/2023A4toot

006020097

Тайлант онд 15,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 28,376.7 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 43,376.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,771,967.08	6,604,616.00
33	АВЛАГА	2,401,267.08	-
335	Бусад авлага	2,401,267.08	-
3351	Байгууллагаас авах авлага	1,267.08	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,400,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,370,700.00	6,604,616.00
354	Хангамжийн материал	2,370,700.00	6,604,616.00
35410	Бичиг хэргийн материал	270,700.00	1,499,500.00
35420	Аж ахуйн материал	-	3,225,100.00
35440	Түлш, шатах тослох материал	2,100,000.00	16.00
35470	Бусад хангамжийн материал	-	1,880,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,529,795.36	47,050,618.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,529,795.36	47,050,618.24
392	Биет хөрөнгө	10,529,795.36	45,800,618.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,889,900.00	48,766,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(175,496.64)	(6,396,079.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,852,941.00	3,852,941.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,549.00)	(422,842.96)
393	Биет бус хөрөнгө	-	1,250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(250,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,301,762.44	53,655,234.24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,301,762.44	53,655,234.24
51	Засгийн газрын хувь оролцоо	15,301,762.44	53,655,234.24
512	Хуримтлагдсан үр дүн	15,301,762.44	53,655,234.24
51210	Өмнөх үеийн үр дүн	15,301,762.44	15,301,762.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	38,353,471.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,301,762.44	53,655,234.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	37,686,481.00	330,162,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,770,841.00	28,576,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,770,841.00	28,576,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,770,841.00	28,576,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,770,841.00	28,576,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,915,640.00	301,586,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	211,612,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	211,612,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,915,640.00	89,132,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,415,640.00	44,582,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	44,550,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	841,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	841,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,384,718.56	291,809,428.20

21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,384,718.56	291,809,428.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,225,122.56	217,072,307.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,929,039.00	105,127,300.64
210101	Үндсэн цалин	8,929,039.00	75,516,586.28
210102	Нэмэгдэл	-	6,463,243.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,993,497.16
210104	Урамшуулал	-	6,153,973.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,217,497.92	13,138,165.29
210201	Тэтгэврийн даатгал	1,217,497.92	9,164,135.46
210202	Тэтгэмжийн даатгал	-	993,974.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	795,179.70
210204	Ажилгүйдлийн даатгал	-	196,925.64
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,987,949.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500,000.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	315,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	595,000.00
210304	Байрны түрээс	1,500,000.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,521,000.00	12,816,364.00
210401	Бичиг хэрэг	113,000.00	1,879,760.00
210402	Тээвэр, шатахуун	1,250,000.00	10,063,984.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	97,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	158,000.00	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	631,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	515,000.00	14,124,500.00
210701	Гадаад албан томилолт	-	4,458,500.00
210702	Дотоод албан томилолт	515,000.00	9,666,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,579,540.00	2,103,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,579,540.00	2,103,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,963,045.64	63,652,077.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,750,000.00	56,796,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	213,045.64	6,855,877.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,596.00	74,737,121.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,381,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,381,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	159,596.00	68,934,408.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	159,596.00	68,934,408.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	421,712.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	421,712.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,301,762.44	38,353,471.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,301,762.44	38,353,471.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	32,915,640.00	301,586,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,915,640.00	301,586,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	211,612,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	211,612,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,915,640.00	89,132,200.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,415,640.00	44,582,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,500,000.00	44,550,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	841,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	841,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	26,943,640.00	286,586,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,943,640.00	286,586,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,784,044.00	211,849,078.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,929,039.00	105,126,033.56
210101	Үндсэн цалин	8,929,039.00	75,812,227.01
210102	Нэмэгдэл	-	6,463,244.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,721,279.51
210104	Урамшуулал	-	6,129,282.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,218,765.00	13,138,165.29
210201	Тэтгэврийн даатгал	1,218,765.00	9,164,135.46
210202	Тэтгэмжийн даатгал	-	993,974.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	795,179.70
210204	Ажилгүйдлийн даатгал	-	196,925.64
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,987,949.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500,000.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	315,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	595,000.00
210304	Байрны түрээс	1,500,000.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,630,000.00	4,987,230.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	277,310.00
210402	Тээвэр, шатахуун	1,250,000.00	3,554,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	97,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	914,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	515,000.00	11,724,500.00
210701	Гадаад албан томилолт	-	4,458,500.00
210702	Дотоод албан томилолт	515,000.00	7,266,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,075,600.00	3,161,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,075,600.00	3,161,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,915,640.00	67,601,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,915,640.00	67,601,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,596.00	74,737,121.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,381,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,381,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	159,596.00	68,934,408.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	159,596.00	68,934,408.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	421,712.54
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	421,712.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,972,000.00	15,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,972,000.00	15,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,972,000.00	15,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,972,000.00	15,000,000.00

222001	Тоног төхөөрөмж	3,250,000.00	-
223001	Бусад хөрөнгө	2,722,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	15,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,972,000.00)</u>	<u>(15,000,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	15,301,762.44	0.00	15,301,762.44
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	15,301,762.44	0.00	15,301,762.44
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	15,301,762.44	0.00	15,301,762.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	15,301,762.44	0.00	15,301,762.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	38,353,471.80	0.00	38,353,471.80
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	53,655,234.24	0.00	53,655,234.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,954,000.00	143,097,878.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,954,000.00	143,097,878.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,568,000.00	137,716,878.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,645,400.00	105,126,033.56
210101	Үндсэн цалин	97,284,800.00	75,812,227.01
210102	Нэмэгдэл	54,500,000.00	6,463,244.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.00	16,721,279.51
210104	Урамшуулал	660,600.00	6,129,282.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,268,300.00	13,138,165.29
210201	Тэтгэврийн даатгал	14,462,400.00	9,164,135.46
210202	Тэтгэмжийн даатгал	1,701,600.00	993,974.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,361,200.00	795,179.70
210204	Ажилгүйдлийн даатгал	340,400.00	196,925.64
210205	Эрүүл мэндийн даатгал	3,402,700.00	1,987,949.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,242,400.00	5,110,000.00
210301	Гэрэл, цахилгаан	480,000.00	315,000.00
210302	Түлш, халаалт	1,302,900.00	-
210303	Цэвэр, бохир ус	948,000.00	595,000.00
210304	Байрны түрээс	5,511,500.00	4,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,186,100.00	2,637,230.00
210401	Бичиг хэрэг	281,000.00	277,310.00
210402	Тээвэр, шатахуун	1,204,000.00	1,204,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,200.00	97,020.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,500.00	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	914,400.00	914,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,658,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,658,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,339,800.00	3,161,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,339,800.00	3,161,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,886,000.00	4,885,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,886,000.00	4,885,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,386,000.00	5,381,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,386,000.00	5,381,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,386,000.00	5,381,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	212,454,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	212,454,000.00
122005	Орон нутгийн төсвөөс	-	212,454,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,132,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,132,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,132,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,350,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,066,500.00
210701	Гадаад албан томилолт	4,458,500.00
210702	Дотоод албан томилолт	4,608,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,715,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,715,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,132,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,132,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,582,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,550,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Соёлын салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах. Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлага зохицуулалтаар хангах. Иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмж, чанар үр дүнг сайжруулах” зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,353.5 мянган төгрөгөөр буюу 250.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,401.27	-	(2,401.27)
Бараа материал	2,370.70	6,604.62	4,233.92
Үндсэн хөрөнгө	10,529.80	47,050.62	36,520.82
Нийт хөрөнгө	15,301.76	53,655.23	38,353.47
Өр төлбөр	-	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	15,301.76	53,655.23	38,353.47
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	15,301.76	53,655.23	38,353.47

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тус байгууллага 31,796.0 мянган төгрөгийн бараа материал /үндсэн үйл ажиллагаанд зарцуулах бараа материал болон нэмэлт санхүүжилтээр орсон Засаг даргын нөөц хөрөнгөөр холбогдох бараа материалыг худалдан авсан/, 15,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч 28,376.7 мянган төгрөгийн хөрөнгийг Соёлын яамнаас шилжүүлэн авснаас нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Соёл урлагийн газар аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний А/398 дугаар захирамжаар 3 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн, 2022 оны төсвийн төсөлд санал хүргүүлээгүй байна.

Соёлын яамнаас 2022 оны төсвийг 211,939.8 мянган төгрөгөөр баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийн 215,954.0 мянган төгрөгөөр буюу 4,014.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ч тодотгол хийсэн тушаал шийдвэр байхгүй байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 211,612.4 мянган төгрөгийн, орон нутгаас 841.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 143,097.9 мянган төгрөг буюу 66.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 72,856.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Тайланд онд орон тоо дутуу ажилласан бөгөөд 2022 онд албан конторын барилгагүйгээс түрээсийн төлбөр 7 сар төлж, тайлант оны 8 дугаар сараас аймгийн ЗДТГ-ын байранд үйл ажиллагаагаа явуулснаар түрээсийн төлбөр төлөөгүй зэргээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	419.90	419.90	0	100%
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	419.90	419.90	0	100%
3	71702	Соёл урлаг	300,744.60	300,744.60	0	100%
4	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	206,226.40	206,226.40	0	100%
5	80112	Нийтлэг үйлчилгээ	89,132.20	89,132.20	0	100%
6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	5,386.00	5,386.00	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 44,582.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 44,550.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож тээвэр шатахуунд 2,350.0 мянган, багаж техник хэрэгсэлд 15,000.00 мянган, гадаад албан томилолтод 4,458.5 мянган, дотоод албан томилолтод 4,608.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 62,715.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 215,954.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,239.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 227,233.0 мянган төгрөгийн орлого, 32,123.7 мянган төгрөгийн зарлага, 7 удаагийн 61,623.7 мянган төгрөгийн шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Хувийн авто машин хэрэглэн 7,834.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Хэмнэлтийн тухай хуулийн 6.3-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зайлшгүй хувийн автомашин ашиглах тохиолдолд гэрээ байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Газрын дарга БНСУ-руу томилолтоор ажиллахдаа онгоцны тийзийг үндэсний тээвэрлэгч компаниас худалдаж аваагүй нь Хэмнэлтийн тухай хуулийн 9.2-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	2,400.0	1	2,400.0	100
Нийт дүн	1	2,400.0	1	2,400.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар албан хаагчдад хоолны мөнгө олгохдоо батлагдсан төсвийн дагуу зарцуулсан эсэхийг хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,223.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд: Үндсэн хөрөнгийг орлого авахдаа бөөн дүнгээр авсан, томилолт болон шатахууны зардлыг алдаатай бүртгэл хөтөлсөн.

Аудитаар нийт 895.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 895.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

1. Анхан шатны баримтгүй 220,000.00 төгрөгийн томилолт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7- д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

2. Албан хаагчдад албан томилолтын хугацаанд 675,000.00 (төгрөгийг хоолны мөнгө давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх асуудал илрээгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх зөрчлийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг орлого авахдаа бөөн дүнгээр авсан	1	28,376.70	0	-	1	28,376.70	1	28,376.70	0	-	0	-
Томилолтын зардлыг алдаатай хаасан	2	17,846.98			2	17,846.98	2	17,846.98				
Дүн	3	46,223.68	0	-	3	46,223.68	3	46,223.68	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүй томилолтын зардал олгосон	1	220.00	1	220.00								
Албан хаагчдад албан томилолтын хугацаанд хоолны мөнгө давхардуулж олгосон	1	675.00	1	675.00								
Дүн	2	895.00	2	895.00	0	-	0	-	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй	1	320,981.00			1	320,981.00		
Дүн	1	320,981.00	0	-	1	320,981.00	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хувийн автомашин хэрэглэсэн	1	7,834.13			1	7,834.13		
Газрын дарга БНСУ-руу томилолтоор ажиллахдаа онгоцны тийзийг үндэсний тээвэрлэгч компаниас худалдаж аваагүй	1	2,448.50					1	2,448.50
Дүн	2	10,282.63	0	0	1	7,834.13	1	2448.5
Нийт дүн	3	331,263.63	0	-	2	328,815.13	1	2,448.50